



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар 2/116

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Замын байгууламжийн зураг төсөл хийлгэх /Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг - Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагаа хариуцсан
ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Х.Баярлах - Жаргалант сумын Захирагчийн ажлын
албаны мэргэжилтэн
Т.Гиймаа - Төрийн бус байгууллагын төлөөлөл
Ц.Батзаяа - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Э.Цолмон - Орон нутгийн өмчийн газрын Худалдан
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Н.Эрдэнэцэцэг/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Э.Цолмон /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

02-00704

D:\Tush-A\116-Bo